

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2025/001/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2025 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Аудитор: Б.Үүрийнтуяа
Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (978) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
М.АРМИЯ ТАНАА

2025.03.31 № 319
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Нийгмийн даатгалын сан нь 2024 онд 133,266.0 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 127,541.7 сая төгрөг зарцуулж, 95.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг шинээр нэвтрүүлсэн "Sicos" программаар гаргаж ирүүлсэн.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

3

832502600016

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ЖАЙГҮЛ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>11,867,223,467.97</u>	<u>13,772,188,698.08</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,435,815,756.37	11,262,867,738.38
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг	-	-
31140	Касс арилжааны банк	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,310,815,756.37	11,262,867,738.38
3121	Төгрөг	9,310,815,756.37	11,262,867,738.38
31211	Төрийн сангийн харилцах	21,370,215.63	
31213	Арилжааны банк дахь харилцах	9,289,445,540.74	11,262,867,738.38
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	125,000,000.00	
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	2,431,407,711.60	2,509,320,959.70
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,162,260,044.23	
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,246,271,644.81	1,244,562,083.81
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	-	1,215,333,818.51
335	Бусад авлага	22,876,022.56	49,425,057.38
3351	Байгууллагаас авах авлага	22,876,022.56	35,064,992.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	14,360,065.38
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>11,867,223,467.97</u>	<u>13,772,188,698.08</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>643,002,871.93</u>	<u>1,893,230,870.97</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	643,002,871.93	1,893,230,870.97
413	Өглөг	18,884,751.54	281,648,091.30
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	18,884,751.54	
4136	Бусад өглөг	-	281,648,091.30
41361	Байгууллагад төлөх өглөг	-	38,640,132.98
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	243,007,958.32
414	Урьдчилж орсон орлого	624,118,120.39	1,611,582,779.67
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	624,118,120.39	1,611,582,779.67
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>11,224,220,596.04</u>	<u>11,878,957,827.11</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	11,224,220,596.04	11,878,957,827.11
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	11,224,220,596.04	11,878,957,827.11
51210	Өмнөх үеийн үр дүн	10,229,807,506.16	11,010,647,105.96
51220	Тайлант үеийн үр дүн	994,413,089.88	868,310,721.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>11,867,223,467.97</u>	<u>13,772,188,698.08</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	159,226,762,974.28	182,497,074,139.63
11	ТАТВАРЫН ОРЛОГО	42,659,946,652.11	51,228,727,162.46
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	42,659,946,652.11	51,228,727,162.46
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	29,417,760,859.94	43,299,819,286.91
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,086,398,534.17	4,533,024,558.87
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,661,092,028.24	1,796,623,328.20
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	627,563,741.65	1,599,259,988.48
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	7,867,131,488.11	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	148,301,499.01	172,348,805.57
120	Нийтлэг татварын бус орлого	148,301,499.01	172,348,805.57
120002	Хүүгийн орлого	52,140,787.34	63,191,844.74
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	20,153,953.03	2,168,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,153,953.03	2,168,400.00
120009	Бусад орлого	76,006,758.64	106,988,560.83
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	116,418,514,823.16	131,095,998,171.60
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	14,687,980,509.00	30,467,614,121.60
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	14,687,980,509.00	30,467,614,121.60
1330	Төсвийн захирагчдаас	101,730,534,314.16	100,628,384,050.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	101,730,534,314.16	100,628,384,050.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	158,232,349,884.40	181,628,763,418.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	158,232,349,884.40	181,628,763,418.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,232,880.00	16,105,332.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,232,880.00	16,105,332.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		7,328,172.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,232,880.00	8,777,160.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	158,225,117,004.40	181,612,658,086.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,390,470,913.00	127,762,055,534.40
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	100,390,470,913.00	127,762,055,534.40
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	57,834,646,091.40	53,850,602,552.08
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,834,646,091.40	53,850,602,552.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>994,413,089.88</u>	<u>868,310,721.15</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	-

Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	-	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>994,413,089.88</u>	<u>868,310,721.15</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>160,340,325,696.20</u>	<u>193,831,364,088.90</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	<u>42,615,080,355.66</u>	<u>62,936,684,514.88</u>
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	42,615,080,355.66	62,936,684,514.88
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	29,395,997,407.03	44,760,008,012.09
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,083,465,051.22	4,556,422,172.19
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,659,406,095.89	1,779,180,166.53
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	621,849,528.14	1,613,320,695.87
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	7,854,362,273.38	10,227,753,468.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>137,731,526.38</u>	<u>198,197,824.02</u>
120	Нийтлэг татварын бус орлого	137,731,526.38	198,197,824.02
120002	Хүүгийн орлого	43,080,704.78	63,274,901.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	<u>94,650,821.60</u>	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	94,650,821.60	
120009	Бусад орлого		134,922,922.56
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	<u>117,587,513,814.16</u>	<u>130,696,481,750.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	15,856,979,500.00	30,068,097,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,856,979,500.00	30,068,097,700.00
1330	Төсвийн захирагчдаас	<u>101,730,534,314.16</u>	<u>100,628,384,050.00</u>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	101,730,534,314.16	100,628,384,050.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>158,250,832,750.04</u>	<u>192,004,312,106.89</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>158,250,832,750.04</u>	<u>192,004,312,106.89</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>7,232,880.00</u>	<u>61,717,635.94</u>
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,232,880.00	16,105,332.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		7,328,172.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,232,880.00	8,777,160.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	<u>45,612,303.94</u>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		45,612,303.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<u>158,243,599,870.04</u>	<u>191,942,594,470.95</u>

Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	100,408,953,778.64	127,525,612,103.67
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	100,381,545,935.00	127,525,612,103.67
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,407,843.64	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	57,834,646,091.40	64,416,982,367.28
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,834,646,091.40	64,416,982,367.28
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2,089,492,946.16</u>	<u>1,827,051,982.01</u>
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	≡	≡
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,089,492,946.16	1,827,051,982.01
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,346,322,810.21	9,435,815,756.37
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,435,815,756.37	11,262,867,738.38

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			10,229,807,506.16	10,229,807,506.16
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	10,229,807,506.16	10,229,807,506.16
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн			994,413,089.88	994,413,089.88
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	11,224,220,596.04	11,224,220,596.04
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	11,224,220,596.04	11,224,220,596.04
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(213,573,490.08)	(213,573,490.08)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	11,010,647,105.96	11,010,647,105.96
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			868,310,721.15	868,310,721.15
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	11,878,957,827.11	11,878,957,827.11

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	133,266,047,700.00	127,541,717,435.67

21	УРСГАЛ ЗАРДАЛ	133,266,047,700.00	127,541,717,435.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,809,600.00	16,105,332.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,809,600.00	16,105,332.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,903,300.00	7,328,172.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	11,906,300.00	8,777,160.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	133,246,238,100.00	127,525,612,103.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	133,246,238,100.00	127,525,612,103.67
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	133,246,238,100.00	127,525,612,103.67
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	133,266,047,700.00	82,919,651,309.14
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	30,068,097,700.00	30,068,097,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	30,068,097,700.00	30,068,097,700.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	103,197,950,000.00	52,851,553,609.14
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	103,197,950,000.00	52,851,553,609.14
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		9,435,815,756.37
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		11,262,867,738.38

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Нийгмийн даатгалын газар нь Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах, нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах, улсын нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх, доод шатны байгууллагынхаа үйл ажиллагаанд хяналт тавих, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага.

Аймгийн Нийгмийн даатгалын газар нь “Даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх” эрхэм зорилготой ба “2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий ДААТГАГЧ болох” хэтийн зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Дээрх зорилтын хүрээнд тайлант онд “Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх.” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Нийгмийн даатгалын газар нь Төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай багц хуулиуд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн

Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

тухай хууль болон төсвийн байгууллагуудад мөрдөж байгаа бусад холбогдох хууль, тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан НДЕГ-ын даргын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/169 дүгээр тушаалаар “Нийгмийн даатгалын хэлтэс” гэсэн нэрийг “Нийгмийн даатгалын газар” болгон өөрчилж, газрын даргын 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар бүтэц орон тоог шинэчлэн баталсан байна.

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг шинээр нэвтрүүлсэн “Sicos” программаар гаргаж ирүүлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус газарт дотоод аудит, хяналт шалгалтын тасаг 3 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг ба НДЕГ-ын Дотоод аудит, мониторингийн газраас өгсөн заавар, зөвлөмжийн дагуу ажилладаг байна.

Нийгмийн даатгалын газрын сангийн болон үйл ажиллагаанд 2024 онд дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузель сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/64 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,905.0 сая төгрөгөөр буюу 16.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,435,815.76	11,262,867.74	1,827,051.98
Авлага	2,431,407.71	2,509,320.96	77,913.25
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал			-
Үндсэн хөрөнгө			-
Нийт хөрөнгө	<u>11,867,223.47</u>	<u>13,772,188.70</u>	<u>1,904,965.23</u>
Өр төлбөр	643,002.87	1,893,230.87	1,250,228.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	11,224,220.60	11,878,957.83	654,737.23
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>11,867,223.47</u>	<u>13,772,188.70</u>	<u>1,904,965.23</u>

Мөнгөн хөрөнгө данс оны эцэст 11,262.9 сая төгрөг болж 1,827.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь арилжааны банк дахь дансны үлдэгдэл ба төрийн сан дахь данс үлдэгдэлгүй байна.

Авлага данс оны эцэст 2,509.3 сая төгрөг болж 77.9 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд: Татаас санхүүжилтийн авлага 1,244.6 сая төгрөг, төлбөртэй үйлчилгээний авлага 1,215.3 сая төгрөг, байгууллагаас авах авлага 35.1 сая төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 14.4 сая төгрөг байна.

Татаас санхүүжилтийн 1,244.6 сая төгрөгийн авлага нь Ковидын үед улсаас даатгуулагчдад төрөөс үзүүлсэн нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, санхүүгийн дэмжлэгтэй холбоотой үлдсэн авлага, байгууллагаас авах авлага 35.3 сая төгрөг нь тэтгэмжийн сан хариуцах ээжүүдийн шимтгэл болон ҮОМШӨ-ний сангаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийг сангаас илүү шилжүүлсний авлага, хувь хүмүүсээс авах авлага 14.4 сая төгрөг нь улсын байцаагчийн акт төлбөрийн авлагыг тайлагнасан байна.

Өр төлбөр данс оны эцэст 1,893.2 сая төгрөг болж 1,250.2 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд: байгууллагад төлөх 38.6 сая төгрөгийн өглөг нь сангуудад сан хариуцах ээжүүдийн шимтгэл болон ҮОМШӨ-ний сангаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийг сангаас илүү орж ирсний, хувь хүмүүст төлөх өглөгт 243.0 сая төгрөгийн /ажилгүйдэл, жирэмсэн амаржсаны, хөдөлмөрийн чадвар алдсаны гэх мэт/ тэтгэвэр тэтгэмжүүдийн өглөг байна.

Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв буюу урьдчилж орсон орлого 1,611.6 сая төгрөг ба энэ нь 2024 онд шинээр хэрэгжсэн багц хуулийн хүрээнд Малчин, туслах малчин төр хариуцах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч буй эцэг, эх, 3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа ээжүүдэд төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн 50-100 хувийг төрөөс хариуцсантай холбоотой төрөөс олгосон санхүүжилтийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 654.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 868.3 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 117,596.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийн саналаас нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийг 15,669.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж 133,266.0 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор Нийгмийн даатгалын сангийн анх батлагдсан төсвийг 159.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 133,266.0 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Төрийн албан хаагчдын цалин 2024 онд үнэмлэхүй хэмжээгээр нэмэгдсэнтэй холбоотой цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлуудыг нэмэгдүүлж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 30,068.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 103,197.9 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангаас нийтдээ 133,266.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 30,068.1 сая төгрөгийн, нийгмийн даатгалын сангаас 52,851.6 сая төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, нийт 82,919.7 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 127,541.7 сая төгрөг буюу 95.7 хувьтай байна. Үүнээс нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжид 127,525.6 сая төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжид 16.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Нийгмийн даатгалын сан					
1	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал	19,809.60	16,105.33	3,704.27	81.3%
2	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	133,246,238.10	127,525,612.10	5,720,626.00	95.7%
	Дүн	133,266,047.70	127,541,717.43	5,724,330.27	95.7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Нийгмийн даатгалын сан нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Нийгмийн даатгалын санд 2024 онд худалдан авах ажиллагаа гараагүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын газар нь Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дугаар сарын 06-ний өдөр урьдчилсан байдлаар /шинээр нэвтрүүлж байгаа “Sicos” программтай холбоотой өөрчлөлт гарна гэдэг байдлаар/ ирүүлсэн.

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайланг эцсийн байдлаар 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 311 дугаар албан бичгээр системийн шинэчлэлтэй холбоотой хугацаа хоцроосон гэх тайлбар ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 110,667.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,660.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус сангийн үйл ажиллагаатай холбоотой шалгахаар төлөвлөсөн шалгуур үзүүлэлтүүдээр горим сорил хэрэгжүүлж, хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

4.4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сангийн тайлант онд шилэн дансанд мэдээлэл оруулсан байдлыг шалгахад алдаа, зөрчил илрээгүй. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувь байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн нийгмийн даатгалын сангийн зарцуулалт нь Нийгмийн даатгалын тухай багц хууль тогтоомжтой нийцсэн гэж дүгнэлээ.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацааны хязгаарлалттай байдалтай холбоотой санхүүгийн тайлагнал, эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн, сангийн зарцуулалт, бусад зардал, авлага, өглөгийг бүрэн шалгах боломжгүй тул гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой залруулга гараагүй.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Дүн												

Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								